



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/219

Хэрлэн сум

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор
Ерөнхий боловсролын сургуулиудын дунд Хөлбөмбөгийн
Зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохион
байгуулахад хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлэх зорилгын хүрээнд орон нутагт хөлбөмбөгийн спортыг хөгжүүлэх, биеийн тамираар хичээллэгсдийг нэмэгдүүлэх чиглэлээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Ерөнхий боловсролын сургуулиудын дунд Хөлбөмбөгийн Зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулгад)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дугаар сарын 22-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
“МӨРӨӨДЛИЙН ГООЛ” ЗҮҮН БҮСИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

Чингис хот

2024 оны 04 сарын 22

№	ЗАРДЛЫН НЭР	ХЭМЖИХ НЭГЖ	ТОО ШИРХЭГ	НЭГ БҮРИЙН ҮНЭ	НИЙТ ЗАРДАЛ
1	Хөлбөмбөгийн хаалганы турба	М	3,4	200000	683,100
2	Мөнгөн шагнал	1-р байр	6	200000	1200000
3	Мөнгөн шагнал	2-р байр	6	150000	900000
4	Мөнгөн шагнал	3-р байр	6	100000	600000
5	Зочид төлөөлөгчдийн хүлээн авалт	ш	20	74,500	1,490,000
6	Хөгжим аппаратур зөөх шатахуун				126,900
Аймаг орон нутгаас гаргах зардал					5.000.000